



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 03 сарын 21 өдөр

Дугаар 126

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө данснаас хасах зөвшөөрөл  
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь заалт, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1 дэх заалт, Засгийн газрын 2023 оны 4 дүгээр тэмдэглэл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4 дэх заалт, тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Гаалийн ерөнхий газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 143,000,000.00 (нэг зуун дөчин гурван сая) төгрөгийн балансын үнэ, хурумтлагдсан элэгдэл бүхий, ашиглалтын хугацаа дууссан, Тоёота Ланд круйзер-200 маркийн, 60-86 УБА улсын дугаартай, (JTMHV05J004154397 арлын дугаар) тээврийн хэрэгслийг төрийн өмчийн данс бүртгэлээс хасч Дархан-Уул аймгийн өмчид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Гаалийн ерөнхий газрын дарга Р.Отгонжаргал, Дархан-Уул аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Д.Бат-Эрдэнэ, Дархан-Уул аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга С.Насанбат нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор тээврийн хэрэгслийг данснаас хасах, хүлээлгэн өгөх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийг Дархан-Уул аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд эзэмшүүлэх, засаж сэлбэн ашиглах, үнийг шинэчлэн тогтоож данс бүртгэлд тусгах ажлыг зохион байгуулах;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Тээврийн хэрэгслийг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2024 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ  
132001256  
9-r huraldaan.docx